**МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ**

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2024.10.24 № 03/8793

танай ____________-ны №_____________-т

"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАРТ

Тендер шалгаруулалтын тухай

Танай байгууллагаас зарласан ЭҮТӨҮГ/20240103833 дугаартай "Эд хөрөнгийн даатгал"-ын үйлчилгээ үзүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтын 1 дүгээр багцад оролцсон "Монгол даатгал" ХК-аас, 2, 3 дугаар багцад оролцсон "Бодьдаатгал" ХК-аас, 3 дугаар багцад оролцсон "Практикалдаатгал" ХХК-аас тус тус Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль (цаашид "хууль" гэх)-ийн 59 дүгээр зүйлийн 59.1 дэх хэсэг, Сангийн сайдын 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам" (цаашид "журам" гэх)-ын 4.1-д заасны дагуу гомдол гаргасан байна.

Хуулийн 59 дүгээр зүйлийн 59.6 дахь хэсгийг үндэслэн захиалагчийн шийдвэр буюу үйлдлийн хэрэгжилтийг 2024 оны 10 дугаар сарын 17-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсэн болохыг Сангийн яам 2024 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн 03/8709 тоот албан бичгээр танайд хүргүүлсэн болно.

Иймд хуулийн 59 дүгээр зүйлийн 59.9 дэх хэсэгт заасны дагуу бусад оролцогч нарт энэхүү шийдвэрийг мэдэгдэх, журмын 5.2-т заасны дагуу гомдол гаргагчийн тендерийн баталгааг чөлөөлөхгүй байхыг үүгээр мэдэгдэж байна.

Гомдлыг хянан шийдвэрлэх хугацаанд хуулийн 59 дүгээр зүйлийн 59.7 дахь хэсэгт заасан хугацаа зогсох болно.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Ж.ГАНБАТ

9766016523

"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР"
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР
Найрамдал талбай, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61027
Утас: 976 (757) 7 35 01, Факс: (976) 7035 3002,
Цахим шуудан: info@erdenetmc.mn,
Цахим хаяг: www.erdenetmc.mn

2024.10.28 № ТӨБ-134-12/6831

танай ____________-ны № ____________-т

САНГИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Ж.ГАНБАТ ТАНАА

Материал хүргүүлэх тухай

"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-аас зарласан ЭҮТӨҮГ/20240103833 дугаартай "Эд хөрөнгийн даатгал"-ын үйлчилгээ үзүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтын 1 дүгээр багцад оролцсон "Монгол даатгал" ХК, 2, 3 дугаар багцад оролцсон "Бодь даатгал" ХК, 3 дугаар багцад оролцсон "Практикал даатгал" ХХК-ууд гомдол гаргасны дагуу хянан шийдвэрлэхэд шаардлагатай дараах баримт бичгүүдийг хүргүүлж байгааг хүлээн авна уу. Үүнд:

-Батлагдсан төсөвт өртгийн шийдвэрийн хуулбар,
-Захиалагчийн үнэлгээний хороо томилсон тушаал,
-Захиалагчийн баталсан тендерийн баримт бичиг,
-Оролцогчдын ирүүлсэн тендер,
-Тендерийн нээлтийн тэмдэглэл,
-Үнэлгээний хорооны зөвлөмж, хурлын тэмдэглэл,
-Шалгараагүй болон татгалзсан тухай шийдвэр.

Хүндэтгэсэн,

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР Т.БАТМӨНХ

ЭРДЭНЭС МОНГОЛ НЭГДЛИЙН ГИШҮҮН

612407035386

"ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР"
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР

Найрамдал талбай, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61027
Утас: 976 (757) 7 35 01, Факс: (976) 7035 3002,
Цахим шуудан: info@erdenetmc.mn,
Цахим хаяг: www.erdenetmc.mn

2024.10.28 № ТпБ-134-12/6830

танай ______________-ны № ______________-т

ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

Захиалагчийн шийдвэр гаргах хугацааг сунгах тухай

"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-аас зарласан ЭҮТӨҮГ/20240103833 дугаартай "Эд хөрөнгийн даатгал"-ын үйлчилгээ үзүүлэгчийг сонгох тендер шалгаруулалтын 1 дүгээр багцад оролцсон "Монгол даатгал" ХК, 2, 3 дугаар багцад оролцсон "Бодь даатгал" ХК, 3 дугаар багцад оролцсон "Практикал даатгал" ХХК-ууд нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 59 дүгэр зүйлийн 59.6 дахь хэсэг, Сангийн яамны 2023 оны А/253 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Тендер шалгаруулалтын гомдол хянан шийдвэрлэх журам"-ын 4.1-т заасны дагуу гомдол гаргасан.

Тус гомдлын дагуу Сангийн яам 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 03/8793 дугаартай албан бичгээр хуулийн 59.10-т заасан шийдвэр гаргасан тул хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3 дахь заалтыг үндэслэн захиалагчийн шийдвэр гаргах хугацааг ажлын 15 хоногоор сунгаж байгааг мэдэгдье.

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР Т.БАТМӨНХ

ЭРДЭНЭС МОНГОЛ НЭГДЛИЙН ГИШҮҮН

612407035384

**“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР”**
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР
Найрамдал талбай, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61027
Утас: 976 (757) 7 35 01, Факс: (976) 7035 3002,
Цахим шуудан: info@erdenetmc.mn,
Цахим хаяг: www.erdenetmc.mn

2024.10.28 № ТБ-134-12/6829
танай ______________-ны № ______________-т

МӨНХ ДААТГАЛ ХХК-Д

Гэрээ байгуулах эрх олгосон мэдэгдлийг түр хугацаагаар түдгэлзүүлэх тухай

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас зарласан Багц №1 “Барилга байгууламжийн даатгал”-ын үйлчилгээ үзүүлэгчийг сонгон шалгаруулах ЭҮТӨҮГ/2020103833 дугаартай тендерт оролцсон “Монгол даатгал” ХК-аас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1-д заасны дагуу гомдол гаргасан тул Сангийн яамны 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 03/8793 дугаартай албан бичгээр гүйцэтгэгч сонгох ажиллагаа түр хугацаагаар түдгэлзүүлсэн болохыг мэдэгдье.

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР Т.БАТМӨНХ

MINING
ERDENET
CORPORATION SOE
“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ТӨҮГ
1119232207 ☎ 2074192
ОРХОН АЙМАГ



61240703582

**“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР”**
ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗАР
Найрамдал талбай, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61027
Утас: 976 (757) 7 35 01, Факс: (976) 7035 3002,
Цахим шуудан: info@erdenetmc.mn,
Цахим хаяг: www.erdenetmc.mn

2024. 10. 28 № ТлБ-134-12/ 6828
танай ______________-ны № ______________-т

АРД ДААТГАЛ ХХК-Д

Гэрээ байгуулах эрх олгосон мэдэгдлийг түр хугацаагаар түдгэлзүүлэх тухай

“Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-аас зарласан Багц №2 “Тоног төхөөрөмжийн даатгал”-ын үйлчилгээ үзүүлэгчийг сонгон шалгаруулах ЭҮТӨҮГ/2020103833 дугаартай тендерт оролцсон “Бодь даатгал” ХК-аас Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.1-д заасны дагуу гомдол гаргасан тул Сангийн яамны 2024 оны 10 дугаар сарын 24-ний өдрийн 03/8793 дугаартай албан бичгээр гүйцэтгэгч сонгох ажиллагааг түр хугацаагаар түдгэлзүүлсэн болохыг мэдэгдье.

ЕРӨНХИЙ ИНЖЕНЕР Т.БАТМӨНХ

ЭРДЭНЭС МОНГОЛ НЭГДЛИЙН ГИШҮҮН

6124070355?0